

ГеоГebra Лиценз

Б.Ганчимэг

Монгол Ви И Ти НЕТ ТББ
Өмнөговь аймгийн "Боловсрол-Хөгжил"
төслийн багш, ажилтан

ГеоГebra өдөрлөг 2023
2023.05.13



ГеоГebra



ГеоГebra нь Австри улсын Линц хотод байрладаг. ГеоГebra динамик, математик программ хангамжийн эх код, татац, вэб програмууд болон үйлчилгээнүүд, хэлний файлууд болон холбогдох баримт бичгүүдийг ("ГеоГebra" эсвэл "Програм хангамж") боловсруулж, хөгжүүлэлтийг хийдэг. <https://www.geogebra.org> хаягаар байрлах вэб сайтаараа дамжуулан ГеоГebra(мөн холбогдох нөөц, материалуудыг нийтэлдэг)-г хэрэглэгчдэд хүргэдэг.

Та GeoГebra програм хангамж, материалуудыг зөвхөн холбогдох лицензийн гэрээ, нөхцлийн дагуу ашиглаж болно. Лицензийн гэрээ нь таны програм хангамж, материалыг хэрхэн ашиглаж буйгаас хамаарна



Ашгийн бус хэрэглээ



Та ГеоГебраг ашгийн бус зорилгоор хуулбарлах, түгээх, засварлах, дамжуулах боломжтой. Ашгийн бус зорилгоор ашиглах аливаа хэлбэр нь **ГеоГебрагийн ашгийн бус лиценз**-ийн гэрээний нөхцлийн дагуу явагдана.

АШГИЙН БУС ХЭРЭГЛЭЭ





ГеоГебраг сургууль, эрдэм шинжилгээний ажил, багшлахуй, суралцахуйд дэмжлэг болгох зорилгоор гэр, ЕБС, коллеж, их сургууль дээрээ ашиглах хүсэлтэй суралцагч, багш нар ямар нэгэн арилжааны давуу тал, санхүүгийн ашиг хонжоо олох зорилгогүйгээр ашиглах тохиолдлууд хамаарна.

ГеоГебраг ашиглах нь хувийн болон ганцаарчилсан танхимын хичээл, сургалтаар хязгаарлагдаж байгаа тохиолдолд сургалтын төлбөртэй бүх түвшний сургуулийн багш нарыг үүнд хамруулж үзнэ


Ашгийн хэрэглээ

GeoGebraг ашиг олох зорилготойгоор ашиглах аливаа тохиолдолд тусгай зөвшөөрөл шаардагдах бөгөөд тусгай зөвшөөрлийг заавал авна. Хэрэв та GeoGebraг арилжаа, ашиг олох зорилгоор ашиглахаар төлөвлөж байгаа бол office@geogebra.org хаягаар холбогдож Лиценз болон Хамтын ажиллагааны гэрээ байгуулна




Ашгийн хэрэглээ

Ашгийн хэрэглээнд голчлон ГеоГебраг арилжаа хийх, ашиг олох давуу тал болгон ашиглах, мөнгөн орлого, хөрөнгө бий болгох зорилготойгоор ашиглах, өөрсдийн үйл ажиллагаагаа дэмжихийн тулд ашиглах хүсэлтэй хэвлэн нийтлэгчид, онлайн сургууль, их дээд сургуулиуд болон ашгийн төлөөх бус байгууллагуудыг хамруулан үзнэ.



Ашгийн хэрэглээний жишээ



ГеоГebra (эсвэл холбогдох материал, хэрэглэгдэхүүнүүд)-г боловсролын материал, хэрэглэгдэхүүнийг хийх, хөгжүүлэхэд ашиглан үүнийгээ төлбөртэй (сургуулийн төлбөрийг оруулаад) зарах эсвэл (үнэгүй тараах) зорилготойгоор хэрэглэгч өөрийн арилжаа, ашгын давуу тал болгон ашиглах



АШГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЖИШЭЭ



ГеоГebra (эсвэл холбогдох материал, хэрэглэгдэхүүн)-г сургалтыг дэмжих нөөц, хэрэгсэл эсвэл хянах, үнэлэх хэрэгсэл болгон ашиглах, тус үйлчилгээг төлбөртэйгээр үзүүлэх, хүргэх Зар сурталчилгаа эсвэл ивээн тэтгэгчийн төрлийн орлогыг хангахад туслах зорилгоор ГеоГebra (эсвэл холбогдох материал, хэрэглэгдэхүүн)-г ашиглах.



АШГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЖИШЭЭ



Ном, сэтгүүл, материалыг төлбөртэй эсвэл төлбөргүй тараах, түгээх, зарах эсэхээс үл хамааран академик бус цахим ном, сурах бичиг, сэтгүүлд ГеоГебра (эсвэл холбогдох материал, хэрэглэгдэхүүн)-г ашиглах. Эрдмийн ажил, илтгэл, бага хуралд ашиглахад тусгай зөвшөөрөл, хамтын ажиллагааны гэрээ шаардлагагүйг анхаарна уу!



Ашгийн бус лицензийн нөхцөл



Энэхүү Лиценз нь Үнэгүй Програм хангамжийн Сан (Free Software Foundation) болон Creative Commons Корпорациас нийтэлсэн лицензийн нэмэлт нөхцлүүдийг (лавлагаагаар) тусгасан болно. Эдгээр нэмэлт нөхцөлүүд болон энэхүү Лицензийн нөхцлийн хооронд ямар нэгэн зөрчил гарсан тохиолдолд сүүлийн хувилбарыг баримтална.

Ашгийн бус лицензийн нөхцөл



GeoГebra татцууд, вэб үйлчилгээ болон төрөл бүрийн зохиогчийн эрхийн материал, график, нөөцийг танд хязгаарлагдмал, онцгой эрхтэй бус, хувь хүнд шилжүүлэх боломжгүй, нөөц ашигласны төлбөргүй лицензээр олгосон бөгөөд үүний дагуу та ашиглах, хуулбарлах, GeoГebraг татаж суулгах, вэб үйлчилгээ болон зохиогчийн эрхийн материалыг зөвхөн ашгийн бус зорилгоор (ямар нэгэн гуравдагч этгээдээс төлбөр авахгүйгээр) түгээх, засах, өөрчлөх, дамжуулах, мөн Зохиогчийн эрхийн зохих мэдээллийг оролцуулан (хамгийн багадаа) бидний нэрийг дурдаж, <https://www.geogebra.org> хаягаар байрлах манай вэбсайтын холбоосыг өгч ашиглах боломжтой.

Ашгийн бус лицензийн НӨХЦӨЛ



ГеоГебрагийн эх кодыг Чөлөөт Програм хангамжийн сангаас нийтэлсэн GNU General Public License (хувилбар 3 ба түүнээс хойшхи)-ын нөхцлийн дагуу танд олгосон бөгөөд одоогийн текстийг энэ холбоосоор орж үзнэ үү: <https://www.gnu.org/licenses/gpl.html> ("GPL"). Шаардлага нь гэвэл манай нэрийг (наад зах нь) дурьдах (GPL-ийн шаардлагын дагуу), зохиогчийн эрхийн зохих мэдээлэл, <https://www.geogebra.org> хаягаар байрлах манай вэбсайтын холбоосыг оруулсан байх ёстой.

Ашгийн бус лицензийн нөхцөл



ГеоГebraгийн хэлний файлууд (ГеоГebra програм болон апплетууд дахь хэрэглэгчийн интерфэйсийн бүх "орчуулгын" файлууд), бүхий л Геогебрагийн материал ("ГеоГebra тусламж", "ГеоГebra гарын авлага"-ууд болон ГеоГebra вэб серверээс олох боломжтой бусад бүх баримт бичгийн файлууд) болон ГеоГebra хэрэглэгчийн интерфэйсийн зураг болон файлууд (лого, дүрс, загвар хуудас зэрэг) нь Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike лицензийн (3.0 буюу түүнээс хойшхи хувилбар) дагуу лицензлэгдсэн бөгөөд одоогийн текстийг эндээс олж болно.

Ашгийн бус лицензийн нөхцөл

Програм хангамж (болон холбогдох бүх материал, хэрэглэгдэхүүн) нь ХУДАЛДАХ ЭРХ эсвэл ямарваа нэг зорилго бүхий ТОДОРХОЙЛОЛТ, БАТАЛГААТ ХУГАЦАА, ХЯЗГААРЛАЛТгүйгээр лицензийн дагуу ҮНДЭСЛЭН танд олгогдсон болно. Иймд ГеоГебра нь таны Програм хангамж ашигласны улмаас гаргах ямарваа нэг үр дагаварт хариуцлага (хуулийн дагуу ийм хариуцлагыг үгүйсгэхээс бусад тохиолдолд) хүлээхгүйг анхаарна уу.



Ашгийн бус лицензийн нөхцөл



GeoГebra болон аливаа гуравдагч этгээдийн дэмжлэг, ирээдүйн хөгжүүлэлтийн санал, амлалтгүйгээр Програм хангамжийн (болон холбогдох бүх материал, хэрэглэгдэхүүн) танд лицензийг олгосон болно. Туслах үйлчилгээг Хамтын ажиллагааны гэрээний нөхцлийн дагуу авах боломжтой.

Та энэхүү Лицензийн нөхцлийн дагуу уг програм хангамжийг ашгийн бус зорилгоор ашиглаж байгаа тохиолдолд GeoГebraг олон төхөөрөмж дээр, олон газарт суулгаж болно.

Ашгийн бус лицензийн НӨХЦӨЛ



ГеоГебра программ хангамж (болон холбогдох бүх материал)-тай холбогдох (дэлхийн хаана ч байсан бай) зохиогчийн эрх болон оюуны өмчийн бусад эрх (барааны тэмдэг, логог оролцуулан) нь ГеоГебрагийн өмч (эсвэл гуравдагч этгээдийн материалын хувьд)-ийн материал (програм хангамжийн номын санг оруулаад) тул бидэнд хэрэглэх, эзэмших эрх (гуравдагч этгээдийн лиценз эзэмшигчийн өмч) нь байгаа бөгөөд програм хангамжийг (болон холбогдох бүх материал) гуравдагч этгээдэд ашиглах эрхийг олгох лиценз бий.

Ашгийн бус лицензийн нөхцөл

Энэхүү Лиценз нь таны хувийнх бөгөөд та үүнийг биднээс урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэх, эсвэл гуравдагч этгээдэд ашигтай байдлаар ашиглах зөвшөөрлийг өгөх ёсгүй.

Хэрэв та ГеоГебра программ хангамжийг хэн нэгэн бүхэлд нь эсвэл аль нэг хэсгийг нь (болон холбогдох бүх материал) зөвшөөрөлгүй ашиглаж буйг мэдвэл бидэнд нэн даруй мэдэгдэх хэрэгтэй.



Ашгийн бус лицензийн нөхцөл



Хэрэв энэ Лицензийн аль нэг заалт (үүнд лавлагаагаар оруулсан нэмэлт нэр томъёог оруулаад) холбогдох хууль тогтоомж эсвэл хууль тогтоомжийн дагуу хүчингүй эсвэл хэрэгжих боломжгүй гэж үзвэл энэ нь тухайн лицензээс хасагдсан гэж үзнэ. Ийм орхигдуулсан нь Лицензийн үлдсэн заалтуудын хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй бөгөөд энэ нь бүрэн хүчинтэй хэвээр байх болно.

Энэхүү лицензийг Австрийн хууль тогтоомжийн дагуу зохицуулж, тайлбарлана.

2022 оны 1-р сар

Баярлалаа!



Ganchimeg Baljinnyam
Ganchimeg.gabi

Монгол Ви И Ти НЕТ ТББ
Өмнөговь аймгийн "Боловсрол-Хөгжил" төслийн
багш, ажилтан

